

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 236 дугаар зүйлд дараахь агуулга бүхий 236.6 дахь хэсгийг нэмсүгэй.

1/236 дугаар зүйлийн 236.6 дахь хэсэг:

“236.6.Тэсэрч дэлбэрэх, аюултай болон химийн хорт бодис, орчиндоо аюул учруулж болох бусад бараанд гаалийн шалгалт хийхдээ аюулгүй ажиллагааг хангасан байна.”.

2 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 236 дугаар зүйлийн “236.6” дахь хэсгийн дугаарыг “236.7” гэж, мөн зүйлийн “236.7” дахь хэсгийн дугаарыг “236.8” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.4 дэх заалтын “үйлдвэрлэх,” гэсний дараа “пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, ашиглах,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “химийн хорт болон аюултай бодис” гэсний өмнө “тэсэрч дэлбэрэхээс бусад” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4 дэх заалтын “үйлдвэрлэх,” гэсний дараа “импортлох, экспортлох,” гэж, мөн заалтын “төгрөг” гэсний дараа “, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, ашиглах тусгай зөвшөөрлийг олгоход 1 250 000 төгрөг” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг